



ashid

Asset Management

АШИД АРВИЖИХ ХАМТЫН ХОС

The background of the cover features a lush green tree on the left and a portion of a blue and green globe on the right. A large, semi-transparent grey arrow points downwards from the top left towards the bottom left corner.

2026

II УЛИРЛЫН ТАЙЛАН



АГЛУЛГА

01.

Ашид Арвижих ХОС-ийн хөрөнгө оруулалтын бодлого

02.

Ашид Арвижих ХОС-ийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл

03.

Ашид Арвижих ХОС-ийн хөрөнгө оруулалтын багц

04.

Дотоод, гадаад зах зээлийн орчин

05.

Ашид Арвижих ХОС-ийн үйл ажиллагааны тойм

06.

Ашид Арвижих ХОС-ийн мэдээллийн ил тод байдал



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО

Ашид Арвижих Хамтын ХОС-ын хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлж буй Ашид Ассет Менежмент ХХК-иас жил бүр эрхлэн гаргадаг Capital Markets Outlook болон 2026 оны олон улсын эдийн засаг, хөрөнгийн зах зээлийн чиг хандлагын дагуу Сангийн хөрөнгө оруулалтын бодлогод үндэслэн тухайн жилийн сангийн хөрөнгө оруулалтын стратеги, баримтлах бодлогыг тодорхойлж, нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлаар баталгаажуулж ажиллаж байна.

Сангийн хөрөнгө оруулалтын хорооны судалгаанд үндэслэн 2026 онд тогтмол орлого бий болгох өрийн хэрэгсэл болон өсөлтийн потенциал өндөр хувьцааны хөрөнгө оруулалтын стратегиудыг хослуулан хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтын багцаа бүрдүүлж, тогтмол хяналт үнэлгээ хийн, ахин тэнцвэржүүлж ажиллаж байна.

Хүснэгт 1. Сангийн хөрөнгө оруулалтын жишиг багц

Хөрөнгө оруулалтын хэрэгсэл	Стратеги	Багцад эзлэх хувь	Зах зээл
Нээлттэй ХК-ийн хувьцаа	Өсөлтийн	45%	Дотоод, гадаад
Өрийн хэрэгсэл	Тогтмол орлого	50%	Дотоод, гадаад
Бэлэн мөнгө ба хадгаламж	Тогтмол орлого	5%	Дотоод

2025 оны сангийн хөрөнгө оруулалтын стратегийн дагуу тогтмол орлого бий болгох стратегийн хувьд сан нь МХБ болон ББЗЗ дээр нээлттэй арилжаалагдаж буй эрсдэл багатай, тогтмол өгөөжтэй өрийн хэрэгслүүдэд сангийн нийт хөрөнгийн 50 хувьд, өсөлтийн стратегийн хувьд дотоод, гадаадын хөрөнгийн бирж дээрх, тогтвортой үйл ажиллагааны орлоготой, зах зээлд танигдсан, өсөлтийн потенциал өндөр, тогтмол ногдол ашгийн бодлоготой, эрсдэл тооцсон өгөөж хамгийн өндөр байхуйц компаниудын хувьцаанд сангийн нийт хөрөнгийн 45 хувийг тус тус хөрөнгө оруулан ажиллаж байна.

Хувьцааны хувьд олон улсын зах зээлд дахь хөрөнгө оруулалт нь валютын эрсдэлээс хамгаалах (hedging), дэлхийн тэргүүлэх компаниудын өсөлтөөс өгөөж хүртэх зорилготой тул зах зээлийн үнэлгээ, нэр хүнд сайтай (blue-chip) хувьцаануудыг хиймэл оюун ухаан, технологи, эрүүл мэнд зэрэг эдийн засгийн тэргүүлэх салбараар ангилж, 10 хувийг хөрөнгө оруулалт хийсэн.

Мөн тус сан нь нээлттэй буюу нэгж эрхээ буцаан худалдан авах үүргийг нэгж эрх эзэмшигчдийнхээ өмнө хүлээж буй тул сангийн хөрвөх чадвар, нэгж эрх буцаан зарах хүсэлтийг хангахын тулд нийт хөрөнгийн 5 хүртэлх хувийг бэлэн мөнгө болон банкны богино хугацаат хадгаламжид хөрөнгө оруулж байна.



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ

“Ашид Арвижих” хамтын ХОС нь 2026 оныг эргэлтэнд буй 6'243'380 ширхэг нэгж эрхтэйгээр, 788'343'436 төгрөгийн цэвэр хөрөнгөтэйгээр хөрөнгө оруулалтын үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Сан нь 2026 оны II-р улирлын байдлаар нийт 184'979 ширхэг нэгж эрх нэмж худалдан, 1'197'632 ширхэг нэгж эрх буцаан худалдан авсан бөгөөд сангийн эргэлтэнд буй нэгж эрхийн хэмжээ 5'230'727 ширхэг хүрч, цэвэр хөрөнгийн үнэлгээ 689'902'199.24 төгрөг болсон.

Хүснэгт 2. Сангийн цэвэр хөрөнгийн үнэлгээ, өгөөж

Цэвэр хөрөнгийн үнэлгээ	689,902,199.24
Өгөөж /хувиар, оны эхнээс/	7.07%
Өгөөж /хувиар, сүүлийн 12 сар/	+18.28%
Эргэлтэнд буй нэгж эрхийн тоо	5,230,727
Нэгж эрхийн цэвэр хөрөнгийн үнэлгээ	131.89

Дотоодын хөрөнгийн зах зээлд 2026 оны 2-р сараас эхлэн компаниудын тайлан, ногдол ашиг тараалт, бүртгэлийн өдөр зэргийн улмаас хувьцааны ханшийн хэлбэлзэл үүсч, сангийн нэгж эрхийн цэвэр хөрөнгийн үнэлгээ уналттай байсан хэдий ч 4 сараас эхлэн ногдол ашиг тараалт болон гадаад зах зээлийн сэргэлттэй холбоотойгоор эргэн өсөж он гарснаас хойш 7.07%, сүүлийн 12 сарын хугацаанд 18.28% өсөлттэй байна. Оны хоёрдугаар хагасаас эдийн засаг тогтворжиж, хөрөнгийн зах зээл болон хувьцааны арилжаа идэвхжих хүлээлттэй байна.

График 1. Сангийн нэгж эрхийн цэвэр хөрөнгийн үнэлгээ






03 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАГЦ

Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаар батласан 2026 онд баримтлах сангийн хөрөнгө оруулалтын стратегийн дагуу хөрөнгө оруулалтын багц дах хувьцаа буюу өмчлөлийн хэрэгслийн хэмжээг хэвээр хадгалж, өрийн хэрэгслийн хэмжээг нэмэгдүүлж зохистой харьцаанд барьж ажилласан. Мөн сангийн эзэмшиж байсан компанийн бондуудын хугацаа дуусч эргэн төлөлт хийгдсэн бөгөөд ОТС буюу Биржийн бус зах зээл дээрх гаргасан ЗээлМН бондод шинээр хөрөнгө оруулалт хийсэн.

Сангийн хөрөнгө оруулалтын багцыг хөрөнгө оруулалтын хэрэгслүүдээр нь ангилж харвал сангийн нийт хөрөнгийн 45.9 хувийг өмчлөлийн хэрэгсэлд хөрөнгөд оруулсан бөгөөд үүний 31.4 хувийг дотоодын хувьцаа, 14.5 хувийг гадаадын хувьцаануудад хөрөнгө оруулсан байна. Сангийн нийт хөрөнгийн 53.8 хувийг тогтмол орлоготой өрийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийсэн бол 0.3 хувийг бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийсэн.

График 2. Сангийн хөрөнгө оруулалтын багц, хөрөнгө оруулалтын хэрэгслээр



Сан 2024 онд хөрөнгө оруулалт хийсэн АПУ ХК [MSE:APU], Хаан банк ХК [MSE:KHAN] зэрэг дотоодын зарим хувьцаануудыг, 2025 онд хөрөнгө оруулалт хийсэн Advanced Micro Devices [NASDAQ:AMD], Marvell technology Inc [NASDAQ:MRVL], Microsoft Corp [NYSE:MSFT], NextEra Energy Inc [NASDAQ:NEE] хувьцаануудын хамт худалдсан. Мөн I улиралд хөрөнгө оруулалт хийсэн Credo Technology Group Holding Ltd [NASDAQ:CRDO] хувьцааг 98% ашигтай худалдаж, шинэ хөрөнгө оруулалт хийснээр сангийн хөрөнгө оруулалтын багц зохистой харьцааны шаардлагыг хангав.


Сангийн Хөрөнгө оруулалтын хороо ээлжит хурлыг сар бүр, ээлжит бус хурлыг тухай бүр зохион байгуулж буй бөгөөд олон улсын болон дотоодын эдийн засаг, геополитикийн нөхцөл байдал, хөрөнгийн зах зээлийн төлөвт үндэслэн сангийн дотоод болон гадаад хувьцааны багцыг идэвхитэй удирдах судалгааг тогтмол хийж байна. Нэгж эрх эзэмшигчдийн хурлаар танилцуулсан 2026 оны хөрөнгө оруулалтын стратегийн дагуу сангийн хөрөнгө оруулалтын багцыг зорилтот ханшид хүрсэн хувьцааг арилжиж, зарим хувьцаануудаас ногдол ашгийн өгөөж хүртэх, нэмж хөрөнгө оруулалтыг хийх зэргээр идэвхитэй удирдан ажиллаж байна.



03 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАГЦ

Сангийн хөрөнгө оруулалтын багцыг үйл ажиллагаа явуулж буй эдийн засгийн сектороор нь ангилж харвал санхүү 30.2 хувь, хүнсний үйлдвэрлэл 20.8 хувь, банк 14.1 хувь, үл хөдлөх 13.1 хувь, мэдээллийн технологи 10.1 хувь болон худалдаа 6.7 хувь тус тус голлон бүрдүүлж байна. 2026 он гарсаар сангийн хөрөнгө оруулалтын багцын ахин тэнцвэржүүлэлт хийгдэж мэдээллийн технологи, санхүүгийн салбаруудад хийсэн хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж, хүнс үйлдвэрлэл, аялал жуулчлалын салбарын хэмжээ буурсан. Гадаад багцын хувьд өргөн хэрэглээ, санхүү, мэдээллийн технологи, биотехнологи, сэргээгдэх эрчим хүчний салбарын хувьцаануудад хөрөнгө оруулалт хийсэн.

График 4. Сангийн хөрөнгө оруулалтын багц, шинэ хөрөнгө нэмэгдснээр, сектороор



Салбаруудын голлох хөрөнгө оруулалт

Хүснэгт 3. Сангийн голлох хөрөнгө оруулалт, салбараар

Санхүү 35.3%	Худалдаа 22.8%	Хүнсний үйлдвэрлэл 17.9%
Мандал даатгал ХК Сэндли бонд Соно бонд WeBull Corporation	Смарт бонд Нэкст бонд Дархан нэхий ХК	АПУ ХК Түмэн шувуут ХК



03 онцлох хөрөнгө оруулалтууд

Сангийн хөрөнгө оруулалтын стратегийн дагуу экзит хийсэн болон хараахан экзит хийгээгүй, зорилтот ханшид хүрээгүй байгаа позицуудын өгөөж болон хөрөнгө оруулалт хийсэн хугацааг дээрх графикт харуулж байна.

График 5. Сангийн хөрөнгө оруулалтын өгөөж, хугацааны хамаарал



Сан Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн ХК [MSE:ERDN]-д хийсэн хөрөнгө оруулалтаас хамгийн өндөр буюу **206.9%** өгөөжийг 36 сарын хугацаанд бий болгосон бөгөөд уг позицыг барьсан хэвээр байна.

Дархан Нэхий ХК [MSE:NEH]-д сан анх үүсгэн байгуулагдах үед хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд 27 сарын хугацаанд тус бүр **38.8%** өгөөжтэй ажилласан ба зорилтот ханшид хүрсэн тул позицын хааж, ашгийг хэрэгжүүлсэн. Сан 2025 оны 10-р сард хийсэн үнэлгээгээр **Хаан банк ХК [MSE: KHAN]**-ийг хямд үнэлгээтэй гэж үзэн нэмж хөрөнгө оруулалт хийж 9 сарын хугацаанд нийт **28.4%** өгөөжтэй ажилласан байна. Мөн **Инновэйшн Инвэстмэнт ХК [MSE:QPAY]** 6 сарын хугацаанд эзэмшиж **23.8%** өгөөж бий болгосон ба хүлээгдэж буй ногдол ашгийн өгөөж **21.9%**, нийт өгөөж **45.7%** хүрэх хүлээлттэй байна.

Гадаад багцын хувьд

- **Advanced Micro Devices Inc [NASDAQ:AMD]** 15 сарын хугацаанд эзэмшин **155.0%**;
- **Credo Technology Group [NASDAQ:CRDO]** 3 сарын хугацаанд эзэмшин **97.9%**;
- **NextEra Energy Inc [NYSE:NEE]** 15 сарын хугацаанд эзэмшин **20.3%**;
- **Marvell Technology Inc [NASDAQ:MRVL]** 15 сарын хугацаанд эзэмшин **18.3%**;
- **Microsoft Corporation [NASDAQ: MSFT]** 30 сарын хугацаанд эзэмшин **10.4%** өгөөж хүртсэн зэрэг онцлох хөрөнгө оруулалтыг хийж ажиллав.



04 ГАДААД ЗАХ ЗЭЭЛИЙН ОРЧИН

ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ: ДАЙНЫ ШОКООС СЭРГЭЛТ ХҮРТЭЛ, ӨНДӨР ИНФЛЯЦИ - УДААН ӨСӨЛТИЙН ЗАМААР

ТОДОРХОЙГҮЙ БАЙДАЛ ШИНЭ ШАТАНД ШИЛЖЛЭЭ

2026 он гарсаар дэлхийн эдийн засаг өндөр өсөлтийн мөчлөгөөс гарч, илүү эмзэг, тодорхой бус орчинд шилжиж, шинэ төрлийн эрсдэлүүд бодитоор илэрч, зах зээлд нөлөөлж эхэллээ. Гагцхүү эдгээр эрсдэлүүд таамагласнаас илүү хурдан, илүү хурц хэлбэрээр биелэлээ олж байна. 2 дугаар сарын сүүлээр эхэлсэн АНУ-Израиль-Ирны дайн дэлхийн эрчим хүчний зах зээлийг дөрвөн сар гаруй хугацаанд царцааж, инфляцыг өдөөж, төв банкуудын бодлогын орон зайг улам хумьсан. Оны эхний хагасын байдлаар дайн саармагжин энхийн хэлэлцээр өрнөж, эрчим хүчний ханш буурч эхэлсэн ч, ханшийн өсөлтийн үр дагавар геополитик, мөнгөний бодлого, хөрөнгийн зах зээлийн хооронд шинэ тэнцвэргүй байдал үүсээд байна.

Олон улсын байгууллагууд 6 дугаар сард нийтэлсэн шинэчилсэн төсөөллүүддээ дэлхийн эдийн засгийн өсөлтийг эрс доогуур харж эхэллээ. ОУЭЗХАБ (OECD), Дэлхийн банк, НҮБ зэрэг байгууллагууд бараг нэгэн зэрэг 2026 оны дэлхийн өсөлтийг өмнөх (1-р сарын) төсөөллөөс 0.5-0.8 нэгж хувиар бууруулж 2.5% хүрэх таамгийг дэвшүүлж байна. АНУ-ын эдийн засаг харьцангуй тэсвэртэй хэвээр байгаа боловч өсөлт 2026 онд ойролцоогоор 2.0%-д саарах төлөвтэй гэж ОУЭЗХАБ таамаглаж байна. Хятадын өсөлт мөн 4.5% хүртэл удаашрахаар байгаа нь тарифын бодлого, дотоод эрэлт сулрахтай холбоотой. Инфляц илүү “бүтцийн шинжтэй” болж буй энэ орчинд мөнгөний бодлого төвөгтэй болж, ХНС болон бусад төв банкуудын бодлогын орон зай хязгаарлагдаж байна. АНУ-ын инфляц 5-р сард 4.2% хүрч 3 жилийн дээд түвшинд очсоноор дэлхийн эдийн засаг “өндөр хүү – бага өсөлт”-ийн орчинд шилжих эрсдэл бодит болж буй талаар ХНС-ийн шинэхэн ерөнхийлөгч Кевин Уорш анхны хэвлэлийн бага хурал дээрээ мэдэгдсэн бөгөөд бодлогын хүүг бууруулах бус өсгөх магадлалтай болов.

Хөрөнгийн зах зээлд эсрэгээрээ S&P 500 индекс 7,600-г давж түүхэн дээд амжилтаа тогтоож байгаа ч хэлбэлзэл өндөр хэвээр байна. Технологийн салбар, ялангуяа хиймэл оюун ухаантай холбоотой компаниудын үнэлгээ өндөр түвшинд хадгалагдаж байгаа ч ашигт ажиллагаатай холбоотой эргэлзээ нь ханшийн савлагааг нэмэгдүүлж байна. Харин эрүүл мэнд, өргөн хэрэглээ, эрчим хүч зэрэг салбарууд харьцангуй тогтвортой гүйцэтгэл үзүүлж байна. Нөгөө талаас, эдийн засгийн өсөлт саарах хүлээлт болон эрсдэлээс зайлсхийх хандлага нэмэгдсэнээр бондын зах зээлд сонирхол дахин нэмэгдэж, урт хугацаат өгөөж буурах хандлага ажиглагдаж байна. Ялангуяа ХНС-ийн мэдэгдлийн дараа АНУ-ын 2 жилийн хугацаат ЗГ-ын үнэт цаас огцом өслөө. Гэсэн хэдий ч инфляциар өдөөгдсөн эдийн засгийн удаашрал өгөөжийг хязгаарлах гол хүчин зүйл хэвээр байна. Үүний зэрэгцээ худалдааны зөрчил, нийлүүлэлтийн сүлжээний доголдол, геополитикийн эрсдэлүүд нь дэлхийн эдийн засгийн суурь нөхцөлийг улам төвөгтэй болгож байна.

Эдийн засаг, зах зээл өөр өөр хүүрнэл өгүүлж буй энэ зөрчилдөөн 2026 оны хоёрдугаар хагасын гол сэдэв байх нь тодорхой. Хөрөнгө оруулагчид (1) технологийн салбарын өндөр төвлөрөл, хэт өндөр үнэлгээнээс болгоомжлох, (2) ХНС-ийн бодлого, Ормузын хоолойн эцсийн шийдлийг нягт хянах, (3) багцаа хэт төвлөрүүлэхгүй, инфляцаас хамгаалах шинжтэй хөрөнгөд байршуулахад түлхүү анхаарах нь зохистой байна.



04 ДОТООД ЗАХ ЗЭЭЛИЙН ОРЧИН

ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ: ГАДААД ОРЧНЫ СОРИЛТУУД БА ДОТООДЫН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

2026 оны эхний хагаст Монголын эдийн засаг таамгаас давж хурдтай өссөн ч гадаад орчны эрсдэл, түүнээс үүдсэн инфляцийн өсөлт сорилт хэвээр байна. Оны эхний улиралд ДНБ өмнөх оны мөн үеэсээ 7.9 хувиар өссөн бөгөөд уул уурхай болон үйлчилгээний салбарын идэвхжлээр дэмжигдсэн байна. Энэ нь өмнөх төсөөллүүдээс (жилд 5-6 хувь орчим) мэдэгдэхүйц давсан үзүүлэлт хэдий ч ADB, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагууд жилийн өсөлтийг 5.0-5.7 хувь орчимд тогтворжино гэж төсөөлж байгаа нь эхний улирлын хурдацыг жилийн туршид хадгалахад хүнд сорилттой болохыг илтгэж байна.

Гадаад валютын албан нөөц оны эцэст ойролцоогоор 7 тэрбум ам.долларт хүрч нэмэгдсэн нь төгрөгийн ханшийн дарамтыг тодорхой хэмжээнд бууруулсан ч импортын өндөр хамаарал, ялангуяа шатахуун, өргөн хэрэглээний бараанаас шалтгаалсан эмзэг байдал хадгалагдсаар байна. Мөнгөний хатуу бодлогын нөлөөгөөр 7-8% орчимд тогтворжсон инфляц 2026 оны эхэнд Ойрхи Дорнодын хурцадмал байдал, Ирантай холбоотой зөрчлөөс үүдэлтэй газрын тосны үнийн өсөлтөөр дамжин дахин нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. Шатахууны үнэ тээвэр, хүнс, өргөн хэрэглээний бараанд дам нөлөөлдөг тул инфляцыг суурь түвшинд хадгалах “cost-push” хүчин зүйл болж байна.

Монголбанк ны зүгээс инфляц болон ханшийн дарамтыг хязгаарлах зорилгоор хатуу бодлогын байр сууриа хадгалж, бодлогын хүү болон макро зохистой бодлогын хэрэгслүүдийг чангаруулсан хэвээр байна. Энэ нь ханшийн тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлж байгаа ч нөгөө талаас зээлийн өсөлт, хөрөнгө оруулалт, хувийн хэрэглээг сааруулах нөлөөтэй байна. Түүнчлэн түүхий эдийн үнийн савлагаа, экспортын орлогын бууралтаас шалтгаалан төсвийн орлогод дарамт үүсч, төсвийн сахилга бат чухал асуудал хэвээр байна. Ийм нөхцөлд дунд хугацаанд төсвийн тогтвортой байдлыг хадгалах, орлогын эх үүсвэрийг төрөлжүүлэх шаардлага улам нэмэгдэж байна.

Хөрөнгийн зах зээлийн хувьд мөнгөний хатуу бодлого, хөрвөх чадварын бууралт, хөрөнгө оруулагчдын итгэл сул зэргээс шалтгаалан хувьцааны зах зээлийн гүйцэтгэл хязгаарлагдмал хэвээр байна. MSE Top 20 Index индексийн өсөлт саарч, зах зээлийн идэвхжил буурсан нь хөрөнгө оруулагчид хамгаалалтын стратегид шилжсэнийг илтгэж байна. Харин бодлогын хүү өндөр хэвээр байгаа нь бонд, хадгаламж зэрэг тогтмол өгөөжтэй хэрэгслийн сонирхлыг нэмэгдүүлж байна. Үүний үр дүнд дотоодын зах зээлд хөрөнгө оруулалтын урсгал илүү болгоомжтой болж, эрсдэл багатай, өгөөж тогтвортой актив руу чиглэх хандлага давамгайлж байна. Өрийн хэрэгслийн өгөөжийн муруй эерэг хэлбэртэй хадгалагдаж байгаа нь хөрөнгө оруулалтын багцад тогтмол өгөөжтэй хэрэгслийн жинг нэмэгдүүлэх стратегийг дэмжиж байна.

Оны эхний хагаст Монголын эдийн засаг “давхар шок”-ын байдалтай байна. Нэг талаас уул уурхайн салбарын сайн гүйцэтгэл, түүхэн дээд экспортын хэмжээ, ГВАН нөөц зэрэг эерэг хүчин зүйлс ажиглагдаж байгаа бол, нөгөө талаас инфляцын огцом өсөлт, улс төрийн тогтворгүй байдал, мөнгөний хатуу бодлого зэрэг эрсдэлүүд давхцаж байна. Ийм нөхцөлд хөрөнгө оруулагчдын хувьд өндөр өгөөж эрэлхийлэхээс илүүтэй эрсдэлийг удирдах, багцын тэнцвэрийг хадгалах, уян хатан стратеги баримтлах нь илүү оновчтой хэвээр байна.



05 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ



Сангийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулав.

Сангийн 2025 оны нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 03 сарын 25-ний өдөр цахимаар болж өнгөрөв. Хуралд нийт 34 иргэн 2 хуулийн этгээд, нийт саналын эрхтэй нэгж эрх эзэмшигчдийн 80.0 хувь оролцов. Хурлаар дараах асуудлыг хэлэлцэн баталсан.

1. Сангийн 2025 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах;
2. Сангийн 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах;
3. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах;
4. Сангийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр Шуураагийн Түмэнбаяр, Улам-Өрнөхийн Цолмонбаяр, Замбалын Ганболд нарыг сонгох;
5. Сангийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Эрдэнэбатын Эрдэнэцэцэг, Батбаатарын Мөнхзаяа нарыг улируулан сонгох зэргээр шийдвэрлэсэн.



Сангийн 2025 оны жилийн эцсийн тайланд “Шонхор үнэлгээ аудит” ХХК-уар аудит хийлгэв.

СЗХ-ны 275 дугаар тоот журмын дагуу ХОС-ийн мэдээллийн ил тод байдлын хүрээнд хагас жилийн болон жилийн эцсийн тайланг СЗХ болон нэгж эрх эзэмшигчдэд мэдээлэх ёстой. Мөн зөвхөн СЗХ-д бүртгэлтэй аудитын байгууллагаар жилийн эцсийн тайланг баталгаажуулан, аудитын дүгнэлт гаргуулсан байх ёстой байдаг.

“Шонхор үнэлгээ” ХХК нь 2014 оноос идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа ба 2017 оноос СЗХ-д үнэт цаасны зах зээлд үйлчилгээ үзүүлэгчээр үйл ажиллагаа явуулж буй туршлагатай компани юм.



СЗХ-ны 2025 оны 64 дугаар тоот журмын дагуу холбогдох бүх тайланг боловсруулан мэдээлэв.

Хамтын хөрөнгө оруулалтын сан нь сар бүр нэгж эрхийн арилжааны тайлан, жилийн болон хагас жилийн тайлан, улирал бүр дотоод хяналт, эрсдэлийн үнэлгээ, санхүүгийн тайлан зэргийг боловсруулан СЗХ болон сангийн ТУЗ-ийн хурлаар танилцуулж ажиллаж байна.



Сангийн 2026 оны хөрөнгө оруулалтын бодлого, стратегийн дагуу хөрөнгө оруулалтын багцад шаардлагатай өөрчлөлтүүдийг хийв.

Санд хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэгч ХОМК нь эдийн засаг, хөрөнгийн зах зээлийн судалгаа, шинжилгээг тогтмол гүйцэтгэж, түүнд үндэслэн жил бүрийн сангийн хөрөнгө оруулалтын бодлого, стратегийг тодорхойлдог. Ашид Арвижих Хамтын ХОС-ийн 2026 оны хөрөнгө оруулалтын стратегийн дагуу сангийн хөрөнгө оруулалтын багц дах хувьцааны хэмжээг багасгаж, тогтмол орлоготой өрийн хэрэгсэл болох бонд, ХБҮЦ-ийн хэмжээг нэмэгдүүлж сангийн активын 60 хүртэл хувь байхаар шийдвэрлэн, багцыг дахин хуваарилах шаардлагатай өөрчлөлтүүдийг хийв.



ХОС-ИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

Нөлөө бүхий нэгж эрх эзэмшигчдийн мэдээлэл:

Ашид Арвижих хамтын ХОС-ийн нийт нэгж эрхийн 5 болон түүнээс дээш хувийг дангаараа эзэмшиж буй нэгж эрх эзэмшигчдийн мэдээллийг дор харуулав.

Хүснэгт 6. Сангийн нэгж эрхийн 5 болон түүнээс дээш хувийг эзэмшигчдийн мэдээлэл

Нөлөө бүхий нэгж эрх эзэмшигчдийн кастодиан дансны дугаар*	Сангийн эзэмшлийн хувь	Эзэмшиж буй нэгж эрх
1100038755	15.3%	800,000
1100038954	11.5%	600,000
1100039067	10.3%	536,955
1100039344	9.7%	509,000
1100039345	9.2%	480,248
1100038769	6.2%	323,965

*Хувийн мэдээллийг хамгаалах хуулийн дагуу харилцагчийн мэдээллийг хураангуйлан гаргасан бөгөөд Зохицуулагч байгууллагад дэлгэрэнгүй байдлаар хүргүүлж ажилладаг болно.

Сангийн нэгж эрхийн арилжааны тухай мэдээ:

2026 оны II улирлын байдлаар нэгж эрхийн худалдах болон эргүүлэн худалдаж авах арилжааны мэдээг дор харуулав. Тайлант хугацаанд нийт 195,388 ширхэг нэгж эрхийн 24.1 сая төгрөгийн дүн бүхий арилжаа явагджээ.

Хүснэгт 7. Сангийн нэгж эрхийг худалдсан болон эргүүлэн худалдаж авсан арилжааны мэдээлэл

Хугацаа	Худалдсан нэгж эрхийн тоо	Буцаан худалдаж авсан нэгж эрхийн тоо	Нийт
1-р сар	0	27,979	27,979
2-р сар	79,338	123	79,461
3-р сар	79,863	8,085	87,948
4-р сар	72	74,329	74,401
5-р сар	24,299	274,637	298,936
6-р сар	1,407	812,479	813,886

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн мэдээлэл

Хүснэгт 8. ТУЗ-ын гишүүдийн мэдээлэл

Нэр	Албан тушаал
Ш.Түмэнбаяр	ТУЗ-ын дарга
З.Ганболд	ТУЗ-ын гишүүн
У.Цолмонбаяр	ТУЗ-ын гишүүн
Э.Эрдэнэцэцэг	ТУЗ-ын хараат бус гишүүн
Б.Мөнхзаяа	ТУЗ-ын хараат бус гишүүн

06

ХОС-ИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ


Сангийн үйл ажиллагааны бүтэц зохион байгуулалт:

Ашид Арвижих хамтын ХОС нь Санхүүгийн Зохицуулах Хорооны хууль эрх зүйн хэрэгжилт, Кастодиан банкны сангийн хөрөнгийн тухайлсан бүртгэл, Хөрөнгө Оруулалтын Менежментийн Компанийн хөрөнгийн удирдлага гэсэн 3 талт хяналтын доор үйл ажиллагаа явуулдаг.

График 6. Сангийн үйл ажиллагааны схем



Ашид Арвижих хамтын ХОС-ийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг та **invest.ashidasset.mn** сайтад өөрийн бүртгэл болон **ashidasset.mn Сангууд** цэснээс харах боломжтой.



Ашид - Ашигтай, Хүртээмжтэй

Холбоо барих

1504 тоот, Твин тауэр-1,
2-р хороо, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар

 +976-77661112

 www.ashidasset.mn
info@ashidasset.mn